

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

| | | |
|-------|---|----|
| 1 | Аудитын гэрчилгээ | 2 |
| 2 | Аудитын тайлан..... | 4 |
| 2.1. | Оршил..... | 4 |
| 2.3. | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт..... | 4 |
| 2.4. | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.5. | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 5 |
| 2.6. | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 5 |
| 2.7. | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 5 |
| 2.8. | Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 6 |
| 2.9 | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 6 |
| 2.10 | Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 7 |
| 2.11. | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 7 |
| 2.12. | Шилэн дансны мэдээлэл | 7 |
| 2.12. | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 7 |
| 2.13. | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 8 |
| 3 | Менежментийн захидал..... | 9 |
| 4 | Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 11 |
| 4.1 | Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 11 |
| 4.2 | Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 12 |
| 4.3 | Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 14 |
| 4.4 | Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 16 |
| 4.5 | Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 17 |
| 5 | Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 20 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УҮГ | Улсын Үйлдвэрийн газар |
| БСШУСЯ | Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам |



СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА
Г.ЭРДЭНЭБАТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.08.19 № 06/526
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёл урлагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Соёл урлагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Соёл урлагийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Соёл, урлагийн газрын захирал Г.Эрдэнэбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулж мэдээллийг байршуулах талаархи зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёл, урлагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 16-наас 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар Юнистар Аудит ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01/18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Соёл, урлагийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Соёлын үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжсэн үндэсний онцлог бүхий үйл ажиллагааг олон улсад шалгарсан, шинэлэг менежмент, туршлагыг ашиглан иргэн бүрт хүргэх, соёлоор дамжуулан Монгол хүний амьдралын чанарыг сайжруулж, нийгэм эдийн засгийн хөгжилд соёл, урлагийн эзлэх байр суурь, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 04 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар гэж байгуулагдсан бөгөөд Улсын хэмжээнд соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй байгууллага байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Татварын тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулинд өөрчлөлт орсон.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Соёл, урлагийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамтай нийцээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогийн баримт бичгийг өөрийн байгууллагын онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж ажиллах шаардлагатай.

Соёл урлагийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Acolous 4.0 санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Соёл, урлагийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Соёл, урлагийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 23 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,602,126.9 мянган төгрөгөөс тооцон 16,021.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 16,417.6 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзэн 2019 санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнгээр авсантай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 112.6 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материалын дансны үлдэгдэл буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /мянган төгрөг/ | | |
|---|-----------------|-----------------|----------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 500.8 | - | (500.8) |
| Бараа материал | 1,419.0 | 528.0 | (891.0) |
| Үндсэн хөрөнгө | 23,412.9 | 24,692.1 | 1,279.3 |
| Нийт хөрөнгө | 25,332.7 | 25,220.1 | (112.6) |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 25,332.7 | 25,220.1 | (112.6) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 25,332.7 | 25,220.1 | (112.6) |

Авлага дансны үлдэгдэл буурсан нь тайлант оны эхэнд байсан тооцооны үлдэгдлийг хаасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны бараа материалын үлдэгдлээс бичиг хэргийн болон аж ахуйн материалыг зарцуулсантай холбоотой. Тайлант онд 9,306.9 мянган төгрөгийн хангамжийн материал худалдан авч, 10,197.9 мянган төгрөгийн хангамжийн материал зарцуулж 527.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5.5 хувиар өссөн нь төсвийн хөрөнгөөр 7,921.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авснаар нэмэгдэж, 6,642.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурч, цэвэр дүнгээр 1,279.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Биет бус хөрөнгө нь тайлант үеийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 25,220.1 мянган төгрөг болж буурсан нь тайлант онд 112.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласантай холбоотой байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Соёл урлагийн хөтөлбөрт зориулан 1,210,491.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдсаныг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр урсгал зардалд нийт 1,191,441.0 мянган төгрөг зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө 294,024.0 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 100,000.0 мянга, хандив тусламжаар 37,241,7 мянган төгрөг буюу нийт 431,265.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжид 428,876.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,389.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 23 эрсдэл тодорхойлж, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 24 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн 2 алдаа зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй

2.12. Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Соёл урлагийн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Соёл урлагийн газар нь Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”, Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмын дагуу 2019 онд 25 мэдээллийг шилэн дансны цахим хаягаар улирал бүрийн хуулийн хугацаандаа, 49 мэдээллийг хугацаа хоцроож, 32 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 1 удаа, батлагдсан төсөв гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 2 удаа, хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх хураамж 11 удаа, цалингийн зардлаас бусад 5 саяас дээш орлого, зарлагын гүйлгээг 2 удаа, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаар 11 удаа, тендерийн мэдээлэл болон худалдан авах ажиллагаанд хийсэн дүгнэлт бусад шалгалтын дүнд 22 удаа тус тус хугацаа хоцроож мэдээлсэн.

Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт 12 удаа, аудитын зөвлөмж, дараа жилийн төсөв, санхүүгийн тайлан хагас жилээр тус бүр 1 удаа, 5 саяас дээш худалдан авалтын тухай 12 удаа, цалингийн зардлаас бусад 5 саяас дээш орлого, зарлагын гүйлгээг 3 удаа, худалдан авах ажиллагааны тайлан 1 удаа, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 1 удаа тус тус мэдээлэл байршуулаагүй байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 500.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 74 тогтоолоор батлагдсан Монгол Улсын нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд гарч байгаа түүхэн тэмдэглэлт үйл явдлыг архивлан хадгалах зорилгоор бүтээж байгаа Түүхийн хүрд баримтад кино мэдээ, хүүхдэд зориулан бүтээх уран сайхны болон хүүхэлдэйн киноны зардлыг улсын төсөвт суулгаж Монгол кино УҮГ-т өгөх тогтоолыг үргэлжлүүлж явна гэсэн хариу өгсөнтэй холбоотой байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй алдаа зөрчлийн дүн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй дүгнэлт”

Соёл, урлагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсгийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, заавартай нийцэхгүй байна.

Энэ нь үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэл, тайлагнал, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдаагүй, ашиглалтгүй байх.

1.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж, баталж, дагаж мөрдөх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрч байна. БСШУСЯ-ны Санхүүгийн хөрөнгө оруулалтын газарт танилцуулснаар 2020 онд Соёл, урлагийн салбарын санхүүгийн үйл ажиллагаанд тохируулан шинэчилнэ.

2. Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 2019 онд 106 мэдээллийг байршуулахаас 25 мэдээллийг хугацаандаа, 49 мэдээллийг хугацаа хоцроож, 32 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлэл байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хууль болон түүнтэй холбогдон гарсан журам, дүрэм, заавартай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Шилэн дансанд мэдээллийг дутуу байршуулах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар 7.1.3-д тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” мэдээлнэ гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|----------------------|----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,919,822.00 | 527,988.00 |
| 33 | АВЛАГА | 500,833.00 | 00.00 |
| 335 | Бусад авлага | 500,833.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 500,833.00 | 00.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 1,418,989.00 | 527,988.00 |
| 354 | Хангамжийн материал | 1,418,989.00 | 527,988.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 511,000.00 | 00.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 907,989.00 | 472,989.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 54,999.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 23,412,859.20 | 24,692,120.77 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 23,412,859.20 | 24,692,120.77 |
| 392 | Биет хөрөнгө | 22,713,900.81 | 24,281,912.38 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 42,722,002.28 | 50,643,482.28 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -29,539,908.88 | -34,425,421.69 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 29,471,128.74 | 29,471,128.74 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -19,939,321.33 | -21,407,276.95 |
| 393 | Биет бус хөрөнгө | 698,958.39 | 410,208.39 |
| 39301 | Програм хангамж | 1,155,000.00 | 1,155,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -456,041.61 | -744,791.61 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 25,332,681.20 | 25,220,108.77 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 25,332,681.20 | 25,220,108.77 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 25,332,681.20 | 25,220,108.77 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 25,332,681.20 | 25,220,108.77 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 25,332,681.20 | 25,332,681.20 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -112,572.43 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 25,332,681.20 | 25,220,108.77 |

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,602,126,990.00 | 1,641,757,296.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,389,890.00 | 00.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 3,389,890.00 | 00.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,389,890.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,389,890.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,598,737,100.00 | 1,641,757,296.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,066,437,100.00 | 1,210,491,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,066,437,100.00 | 1,210,491,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 532,300,000.00 | 431,265,696.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 37,241,696.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 532,300,000.00 | 294,024,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 100,000,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,600,792,707.32 | 1,641,869,868.43 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,600,792,707.32 | 1,641,869,868.43 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,556,884,788.32 | 1,565,042,528.73 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 194,847,602.80 | 242,017,016.00 |
| 210101 | Үндсэн цалин | 169,490,605.80 | 186,274,740.00 |
| 210102 | Нэмэгдэл | 25,356,997.00 | 55,742,276.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,178,267.00 | 30,527,043.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,399,367.00 | 20,269,643.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,694,700.00 | 2,564,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,355,800.00 | 2,051,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 338,900.00 | 512,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,389,500.00 | 5,128,700.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,721,200.00 | 34,807,035.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,547,730.00 | 4,820,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,911,177.00 | 19,246,089.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,927,288.00 | 8,543,046.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,335,005.00 | 2,197,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 571,400.00 | 40,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 571,400.00 | 40,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,620,000.00 | 12,643,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,620,000.00 | 12,643,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,168,175,200.00 | 1,112,972,235.30 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,168,175,200.00 | 1,105,972,235.30 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 7,000,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 137,771,118.52 | 132,035,599.43 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 123,650,000.00 | 125,393,381.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 14,121,118.52 | 6,642,218.43 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 43,907,919.00 | 76,827,339.70 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 30,000,000.00 | 55,387,700.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 24,387,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 1,000,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 13,907,919.00 | 21,439,639.70 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 13,907,919.00 | 21,439,639.70 |

Соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|---|------------------------------------|--------------|-------------|
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 1,334,282.68 | -112,572.43 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 1,334,282.68 | -112,572.43 |

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,598,737,100.00 | 1,641,757,296.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,598,737,100.00 | 1,641,757,296.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,066,437,100.00 | 1,210,491,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,066,437,100.00 | 1,210,491,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 532,300,000.00 | 431,265,696.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 37,241,696.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 532,300,000.00 | 294,024,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 100,000,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,587,049,119.00 | 1,633,835,816.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,587,049,119.00 | 1,633,835,816.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,543,141,200.00 | 1,557,008,476.30 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 194,837,100.00 | 242,017,016.00 |
| 210101 | Үндсэн цалин | 169,480,100.00 | 186,274,740.00 |
| 210102 | Нэмэгдэл | 25,357,000.00 | 55,742,276.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,679,100.00 | 30,026,210.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,900,200.00 | 19,768,810.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,694,700.00 | 2,564,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,355,800.00 | 2,051,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 338,900.00 | 512,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,389,500.00 | 5,128,700.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,608,400.00 | 33,861,035.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,434,930.00 | 4,309,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,911,177.00 | 19,246,089.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,927,288.00 | 8,543,046.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,335,005.00 | 1,762,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 571,400.00 | 94,999.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 571,400.00 | 94,999.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,620,000.00 | 12,643,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,620,000.00 | 12,643,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,168,175,200.00 | 1,112,972,235.30 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,168,175,200.00 | 1,105,972,235.30 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 7,000,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 123,650,000.00 | 125,393,381.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 123,650,000.00 | 125,393,381.00 |

Соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|-----------------------|----------------------|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 43,907,919.00 | 76,827,339.70 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 30,000,000.00 | 55,387,700.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 24,387,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 1,000,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 13,907,919.00 | 21,439,639.70 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 13,907,919.00 | 21,439,639.70 |
| 213304 | Хөрөнгийн | 00.00 | 00.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 11,687,981.00 | 7,921,480.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>00.00</u> | <u>00.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 11,687,981.00 | 7,921,480.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 11,687,981.00 | 7,921,480.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 11,687,981.00 | 7,921,480.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 11,687,981.00 | 7,921,480.00 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | 00.00 | 00.00 |
| 226001 | Гадаад эх үүсвэрээр | 00.00 | 00.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -11,687,981.00 | -7,921,480.00 |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>00.00</u> | <u>00.00</u> |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>00.00</u> | <u>00.00</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|----------------------|--------------|--|
| C01 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 23,998,398.52 | 00.00 | 23,998,398.52 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,334,282.68 | 00.00 | 1,334,282.68 |
| C08 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 25,332,681.20 | 00.00 | 25,332,681.20 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 25,332,681.20 | 00.00 | 25,332,681.20 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -112,572.43 | 00.00 | -112,572.43 |
| D09 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 25,220,108.77 | 00.00 | 25,220,108.77 |

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|--|------------------|------------------|---------------|-------|
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,210,491,600.00 | 1,191,441,032.30 | 19,050,567.70 | 98.4 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,210,491,600.00 | 1,191,441,032.30 | 19,050,567.70 | 98.4 |
| Бараа, үйлчилгээний зардал | 1,155,103,900.00 | 1,136,053,332.30 | 19,050,567.70 | 98.4 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 256,433,700.00 | 242,017,016.00 | 14,416,684.00 | 94.4 |
| Үндсэн цалин | 194,057,500.00 | 186,274,740.00 | 7,782,760.00 | 96.0 |
| Нэмэгдэл | 62,376,200.00 | 55,742,276.00 | 6,633,924.00 | 89.4 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 32,054,300.00 | 30,026,210.00 | 2,028,090.00 | 93.7 |
| Тэтгэврийн даатгал | 21,796,900.00 | 19,768,810.00 | 2,028,090.00 | 90.7 |
| Тэтгэмжийн даатгал | 2,564,300.00 | 2,564,300.00 | - | 100.0 |
| ҮОМШӨ ний даатгал | 2,051,500.00 | 2,051,500.00 | - | 100.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 512,900.00 | 512,900.00 | - | 100.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 5,128,700.00 | 5,128,700.00 | - | 100.0 |
| Хангамж, бараа материалын зардал | 33,865,300.00 | 33,861,035.00 | 4,265.00 | 100.0 |
| Бичиг хэрэг | 5,760,000.00 | 4,309,400.00 | 1,450,600.00 | 74.8 |
| Тээвэр (шатахуун) | 14,372,100.00 | 19,246,089.00 | -4,873,989.00 | 133.9 |
| Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 10,233,200.00 | 8,543,046.00 | 1,690,154.00 | 83.5 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 3,500,000.00 | 1,762,500.00 | 1,737,500.00 | 50.4 |
| Эд хогшил худалдан авах | 8,017,300.00 | 8,016,479.00 | 821.00 | 100.0 |
| Багаж, техник, хэрэгсэл | 8,017,300.00 | 8,016,479.00 | 821.00 | 100.0 |
| Томилолт, зочны зардал | 12,643,600.00 | 12,643,600.00 | - | 100.0 |
| Дотоод албан томилолт | 12,643,600.00 | 12,643,600.00 | - | 100.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 685,238,900.00 | 684,095,611.30 | 1,143,288.70 | 99.8 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 678,238,900.00 | 677,095,611.30 | 1,143,288.70 | 99.8 |
| Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 7,000,000.00 | 7,000,000.00 | - | 100.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 126,850,800.00 | 125,393,381.00 | 1,457,419.00 | 98.9 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 126,850,800.00 | 125,393,381.00 | 1,457,419.00 | 98.9 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 55,387,700.00 | 55,387,700.00 | - | 100.0 |
| Бусад урсгал шилжүүлэг | 55,387,700.00 | 55,387,700.00 | - | 100.0 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 30,000,000.00 | 30,000,000.00 | - | 100.0 |
| Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 24,387,700.00 | 24,387,700.00 | - | 100.0 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.0 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,210,491,600.00 | 1,191,441,032.30 | 19,050,567.70 | 98.4 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,210,491,600.00 | 1,191,441,032.30 | 19,050,567.70 | 98.4 |
| Улсын төсвөөс санхүүжих | 1,210,491,600.00 | 1,191,441,032.30 | 19,050,567.70 | 98.4 |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 17 | 17 | - | 100.0 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 14 | 14 | - | 100.0 |

Соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | |
|-----------------|---|---|---|-------|
| Үйлчлэх ажилтан | 2 | 2 | - | 100.0 |
|-----------------|---|---|---|-------|

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | /төгрөг/ | |
|--|----------------|----------------|----------|---------------|
| | | | Дүн | Хувь |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 428,876,624.00 | 428,876,624.00 | - | - |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 428,876,624.00 | 428,876,624.00 | - | - |
| Бараа, үйлчилгээний зардал | 428,876,624.00 | 428,876,624.00 | - | - |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 428,876,624.00 | 428,876,624.00 | - | - |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 428,876,624.00 | 428,876,624.00 | - | - |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 428,876,624.00 | 428,876,624.00 | - | - |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 428,876,624.00 | 428,876,624.00 | - | - |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 37,241,696.00 | 37,241,696.00 | - | - |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 291,634,928.00 | 291,634,928.00 | - | - |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 100,000,000.00 | 100,000,000.00 | - | - |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 17 | 17 | - | 100.00 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.00 |
| Гүйцэтгэх ажилтан | 14 | 14 | - | 100.00 |
| Үйлчлэх ажилтан | 2 | 2 | - | 100.00 |

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|------------------------------|----------------------|---|----------------------|
| Огноо | Аудитын нэр | 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код |
| 2020.02.20 | | | САГ-2020/177/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Соёл, урлагийн газар | | Мянган төгрөгөөр |

| No | Алдаа зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|----|--|------------|---------------------------------------|--|----------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| A | 3 | 4 | 5 | 8 | 9 |
| 1 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, заавартай нийцэхгүй байна. | - | Зөвлөмж өгсөн. | Ахлах нягтлан бодогч | А.Түвшин |
| 2. | Шилэн дансны цахим хуудсанд 2019 онд 106 мэдээллийг байршуулахаас 25 мэдээллийг хугацаандаа, 49 мэдээллийг хугацаа хоцроож, 32 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлэл байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хууль болон түүнтэй холбогдон гарсан журам, дүрэм, заавартай нийцэхгүй байна. | - | Зөвлөмж өгсөн. | Ахлах нягтлан бодогч | А.Түвшин |

